



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2008 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 01/130

Улаанбаатар хот

Хүн амын амьжиргааны доод түвшинг
батлах тухай

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, ҮСХ-ны даргын зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг: “Хүн амын амьжиргааны доод түвшин”-ий 2008 оны шинэчлэн тооцсон хэмжээг хавсралтаар баталсугай.

Хоёр: Шинэчлэн тогтоосон “Хүн амын амьжиргааны доод түвшин”-ий талаар холбогдох байгууллагад танилцуулж, нийтэд мэдээлэхийг Төрийн захиргаа, удирдлагын газар /Ч.Дагвадорж/-т үүрэг болгосугай.

Гурав: Энэ тушаал гарсантай холбогдуулан “Хүн амын амьжиргааны доод түвшин”-г батлах тухай Үндэсний статистикийн газрын даргын 2008 оны 1/37 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Handwritten signature of P. Byambatseren

П.БЯМБАЦЭРЭН

Үндэсний статистикийн хорооны даргын
2008 оны 10 сарын 09 -ны өдрийн
01/130 тоот тушаалын хавсралт

ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИН, БҮС НУТГААР

УХА0216

Бүс нутаг	Хамрагдах аймаг	Амьжиргааны доод түвшин, төг
1. Баруун бүс	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	94300
2. Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. Орхон	89000
3. Төвийн бүс	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь 5. Сэлэнгэ 6. Төв 7. Дархан-Уул	90800
4. Зүүн бүс	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	85100
5. Улаанбаатар	1. Улаанбаатар	94800